



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 08

Мандалговь

Хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйл, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам"-ын 2.1, 3.2.6.а дугаар заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Орон нутгийн өмчийн албаны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 42-44 ДУА улсын дугаартай, Toyota Сара маркын автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.
2. Автомашиныг худалдах үнийн доод хязгаарыг 1'000'000 /нэг сая/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга /П.Очирбат/-д үүрэг болгосугай.
3. Худалдсан тээврийн хэрэгслийг хөрөнгийн бүртгэлээс хасахыг Орон нутгийн өмчийн албаны дарга /П.Очирбат/-д даалгасугай.

ДАРГА  С.БУДЖАВ



0100000002